



History of the XX Century Mongolia

1990 REVOLUTION: 1. CRUSH OF THE SOCIALIST SYSTEM

LECTURE 11

LECTURER: PROF. OTGONJARGAL SODNOMDARJAA
NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

XX зууны Монголын Түүх

1990 ОНЫ ХУВЬСГАЛ: 1. СОЦИАЛИСТ СИСТЕМ ЗАДРАН
УНАСАН НЬ

ЛЕКЦ 11

ПРОФ.ОТГОНЖАРГАЛ СОДНОМДАРЖАА
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Лекцийн агуулга

- Хүний оюун ухаан, оюун санаа хүний сэтгэлгээний хязгааргүй эрх чөлөөг хаан боогдуулахад нийгэм мөхөл рүү явдгийг мэдэж авна
- Хүн төвтэй онолын мөн чанарыг ойлгоно

XX зууны 80-аад
оны сүүлч 90-ээд
оны эхээр дэлхийн
улс төрийн
байдалд огцом,
гэнэтийн өөрчлөлт
гарч социалист
систем, социализм
маш богино
хугацаанд задран
унав.



<https://www.montsame.mn>

Социализм яагаад ийм богино наслав аа? Энэ нь зайлшгүй байв уу

Аль эсвэл гадны хүчтэй нөлөөллөөс болов уу?
Өөрчлөн байгуулалтын асуудлыг зоригтой тавьж ардчиллын талаар анхлан дугарсан М.С.Горбачёв социализмын эсрэг байсан уу

ЗХУКН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга М.С.Горбачёв 1991 оны 8-р сарын 23-нд ЗХУКН-ыг татан буулгах зарлиг гаргаж ЗХУКН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалаасаа огцорсноо мэдэгдэж, 8-р сарын 24-ндөө ЗХУ-ын Сайд нарын танхимыг татан буулгав. Нэг үгээр хэлбэл Горбачёвын энэ үйлдлээр коммунист дэглэм мөхсөн билээ.



<https://www.montsame.mn>

М.С.Горбачёв “Өөрчлөн байгуулалт шинэ сэтгэлгээ” номондоо “бид социализмыг улам гүнзгийрүүлэхийг хүсэж байна. ...социалист нийгэмд зогсонги байдал үүслээ, ... гэхдээ социализм төрөлх чанараараа эрч хүчтэй нийгэм болохоор хувьсгалт өөрчлөлт хийх чадвартай байдаг нь хамгийн чухал зүйл юм” хэмээн социализмыг ямар ч нөхцөлд амьдрах чадвартай гэж тэрээр бат итгэж байв.



[This Photo](#) by Unknown Author is licensed under [CC BY-SA](#)


Перестройка и новое мышление, Горбачёв
М.С, 1988, Москва Издательство
политической литературы, 36

Яагаад ийм амархан
сүйрэв? Учир
шалтгааныг гаднаас
хайх уу, дотроос уу

ЗХУ нь социализмын
үндсэн зарчмаасаа
Сталины үеэс эхлэн
бүрэн ухарч авторитар
буюу төрийн ноёрхол
дагнасан цэрэгжилтийн
маягийн нийгмийг
байгуулах болсон юм.



[This Photo](#) by Unknown Author is licensed under [CC BY-SA](#)




Социализм нь капитализмтай эсрэг тэсрэг
эвлэрэшгүй зөрчилтэй хэмээх үзлийг
хүний оюун санаанд баттай суулгаснаар
капиталист орнуудыг гүйцэж түрүүлэхийн
тулд тооны хойноос болон зэвсэглэлээр
улайран хөөцөлдөж байсан нь цаанаа
хямрал улам бүр газар авах нөхцөл болж
байв.



www.wikiversity.org

Хүнийг хоёрдугаарт тавьж, хүний оюун ухааныг хүний тархийг үзэл сурталчилжуулан ухааных нь эрх чөлөөг хүчээр хааж боогдуулж эхлэхээр түүхэн үйл явцыг залуурдагч Хүний оюун ухаан саатахад нийгэм зогсонги байдалд ордгийг амьдрал дээр харуулсан юм.



*XX зууны сүүлчээр цаг хугацаа өөрөө
социалист капиталист эсрэг тэсрэг
системийн ялагч, ялагдагчийг тодруулав*

*Социалист системийн сүйрэлд дотоод
шалтгаан нь гадаад шалтгаанаасаа илүү
үүрэг гүйцэтгэсэн юм*

References

1. XX зууны Монголол дахь улс төрийн түүхэн үйл явц, Отгонжаргал С, Бат-Очир Л, Засгийн газрын хэвлэх үйлдвэр, 1996
2. Перестройка и новое мышление, Горбачёв М.С, Москва
Издательство политической литературы, 1988

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА